

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/5/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр	
	Утас: 70373089	Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
	Аудитын менежер: У.Батсүрэн	
	Утас: 70373089	Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
	Ахлах аудитор: С.Батцэцэг	
	Утас: 70373089	Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Пийк ОМ Аудит” ХХК		
Цахим хаяг: peakomauditllc@gmail.com		

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага	23
5.3 Зөвлөмж.....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	31

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОННУ	Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН
ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЧАГНААДОРЖ ТАНАА**

2025.03.14 № 167

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна. байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 42,207.4 сая төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлаас давсан нь дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2024 онд 1,002.5 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал ачуулж, 25.9 мянган тонн ган цувимал бүтээгдэхүүнийг борлуулснаар нийт 291,738.8 сая төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлж, 51,996.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашгийн төлөвлөгөөний биелэлт 100.8 хувиар биелүүлсэн байна.

Тайлант хугацаанд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн экспортын тээврийн үйл ажиллагаанд ашиглаж байсан 535 ширхэг ачааны хагас вагоныг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн нэгдүгээр орлогч даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 10/1978 албан тоотоор “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-ийн эзэмшлийн гэж үзэн татан авснаар тус экспортын тээвэрт ашиглах вагонгүй болсон байна.

4525020294

Вагоны дутагдлыг түрээсийн вагоноор шийдвэрлэхээр 2023 оны 10 дугаар сараас 2024 оны 07 дугаар сар хүртэл вагон түрээсийн тендерийг 11 удаа зарласан боловч амжилтгүй болсон тул нарийвчилсан судалгаа хийж, вагон түрээсийн төлбөрийг зах зээлийн бодит үнэд нийцүүлэн, техникийн тодорхойлолтын шаардлагыг уян хатан болгосноор тендерийг амжилттай зохион байгуулжээ. Ингэснээр “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь түрээсийн 700 ширхэг ачааны вагоноор тээврийн ажлыг гүйцэтгэж, биржийн дуудлага худалдаа хэвийн үргэлжлэн, зорилтот түвшнийг ханган ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2024 онд Монголын хөрөнгийн биржээр нийт 90 удаагийн арилжааг амжилттай зохион байгуулж 1,366.7 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал борлуулах гэрээг байгуулж ажилласан байна.

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1,875.3 төгрөгийн ногдол ашиг зарлаж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу Хуримтлалын санд 13,615.0 сая төгрөгийг хуримтлуулсан нь Монгол Улсын хэмжээнд гуравт жагсаж байна.

Бусад асуудлын хэсэг

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2022 онд төрд шилжсэнээс хойш төрийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, хөрөнгийг үнэн зөв үнэлж бүртгэх тал дээр хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бөгөөд тайлант онд хөрөнгийн дахин үнэлгээг анх удаа хийж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 56,497.3 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлсэн байна.

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2023 онд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 10.0 тэрбум төгрөгийг жилийн 9.8%-ийн хүүтэйгээр 24 сарын хугацаатай зээл авч, уг зээлийг 2024 оны 12 дугаар сард бүрэн төлж барагдуулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан-

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	12,957,616,274.99	52,122,935,268.06
1.1.2	Дансны авлага	15,155,053,226.36	11,055,871,614.31
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,118,716,334.87	2,002,417,486.06
1.1.4	Бусад авлага	539,115,349,066.44	616,152,307,534.25
1.1.6	Бараа материал	309,643,943,820.51	386,527,855,986.30
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	54,766,313,330.26	15,719,903,099.70
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	933,756,992,053.43	1,083,581,290,988.68
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	115,594,198,251.85	175,794,954,206.27
1.2.2	Биет бус хөрөнгө	1,008,561,536.30	711,262,350.92
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	2,586,301,000.00	3,375,149,249.09
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	2,617,689,996.28	2,617,689,996.28
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	121,806,750,784.43	182,499,055,802.56
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,055,563,742,837.86	1,266,080,346,791.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	43,286,582,788.98	50,666,376,932.21
2.1.1.2	Цалингийн өглөг	2,341,405,504.00	2,904,198,254.00
2.1.1.3	Татварын өр	387,678,389,075.79	408,415,705,518.65
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	43,102,605,261.91	42,365,878,005.62
2.1.1.6	Хүүний өглөг	30,642,800,756.76	30,610,868,010.18
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	146,332,695,653.71	244,125,067,477.05
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	1,193,111,527.94	2,956,060,227.94
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,384,208,328.46	6,292,121,179.54
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	656,961,798,897.55	788,336,275,605.19
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	111,105,797,552.13	101,105,797,552.13
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	16,904,962,013.55	13,750,786,813.55

ХТ06433609202399

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	64,683,452,175.90	64,683,452,175.90
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	192,694,211,741.58	179,540,036,541.58
2.2	Өр төлбөрийн нийт дүн	849,656,010,639.13	967,876,312,146.77
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Төрийн өмч	21,353,312,476.16	21,353,312,476.16
2.3.2	Хувийн өмч	-	-
2.3.3	Хувьцаат өр төлбөр	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	56,497,325,605.99
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	184,554,419,722.57	220,353,396,562.32
2.3.11	Эздийн өмчийн дүн	205,907,732,198.73	298,204,034,644.47
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,055,563,742,837.86	1,266,080,346,791.24




2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	249,570,524,749.50	291,738,823,201.16
2	Борлуулалтын өртөг	114,080,893,617.94	124,977,864,329.72
3	Нийт ашиг (алдагдал)	135,489,631,131.56	166,760,958,871.44
4	Түрээсийн орлого	2,313,002,036.37	429,858,880.03
5	Хүүгийн орлого	100,803,281.60	410,483,661.10
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	735,174,133.99	1,159,218,818.39
9	Борлуулалт, маркетингийн зардал	62,483,404,932.40	85,927,104,309.25
10	Ерөнхий ба удирдлагын зардал	24,949,723,017.10	13,751,255,781.46
11	Санхүүгийн зардал	362,089,863.98	733,007,551.09
12	Бусад зардал	4,189,772,153.47	815,949,589.61
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	113,494,630.22	173,745,382.28
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	6,167,604,856.29	3,306,080,892.39
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	52,934,720,103.08	71,013,029,274.22
19	Орлогын татварын зардал	12,890,718,589.23	19,016,469,225.55
20	Татварын дараах ашиг (алдагдал)	40,044,001,513.85	51,996,560,048.67
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	40,044,001,513.85	51,996,560,048.67
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	40,044,001,513.85	51,996,560,048.67
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-



2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	21,353,312,476.16	-	141,829,092,732.79	163,182,405,208.95
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	2,681,325,475.93	2,681,325,475.93
Залруулсан үлдэгдэл	21,353,312,476.16	-	144,510,418,208.72	165,863,730,684.88
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	40,044,001,513.85	40,044,001,513.85
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	21,353,312,476.16	-	184,554,419,722.57	205,907,732,198.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(2,582,622,694.21)	(2,582,622,694.21)
Залруулсан үлдэгдэл	21,353,312,476.16	-	181,971,797,028.36	203,325,109,504.52
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	(13,614,960,514.71)	(13,614,960,514.71)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	51,996,560,048.67	51,996,560,048.67
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	56,497,325,605.99		56,497,325,605.99
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	21,353,312,476.16	56,497,325,605.99	220,353,396,562.32	298,204,034,644.47



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	237,697,358,170.47	361,930,725,216.59
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	234,469,119,929.91	359,204,538,642.56
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,228,238,240.56	2,726,186,574.03
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	238,569,977,510.78	301,601,057,659.14
1.2.1	Ажиллагсдад төлсөн	45,991,519,547.63	58,305,840,515.07
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	15,200,523,873.79	17,261,227,453.49
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	47,137,149,847.68	36,462,676,732.96
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	7,054,555,071.36	9,857,654,837.73
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	73,546,786,851.12	103,119,528,410.11
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	327,561,643.84	693,768,363.01
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	16,636,010,910.08	38,334,918,295.65
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	18,792,459.00	60,500,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	32,657,077,306.28	37,504,943,051.12
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(872,619,340.31)	60,329,667,557.45
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	100,803,281.60	410,483,661.10
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө буруулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	100,803,281.60	410,483,661.10
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,304,969,792.20	3,572,318,772.20
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,046,561,617.20	3,379,882,687.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	258,408,175.00	192,436,085.20
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-



2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,204,166,510.60)	(3,161,835,111.10)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,021,656,807.99	643,925,428.69
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,000,000,000.00	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	21,656,807.99	643,925,428.69
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	231,630,096.91	18,646,438,881.97
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	124,597,106.96	5,001,267,146.86
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	13,614,960,514.70
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	107,032,989.95	30,211,220.41
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,790,026,711.08	(18,002,513,453.28)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,713,240,860.17	39,165,318,993.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,244,375,414.82	12,957,616,274.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,957,616,274.99	52,122,935,268.06

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
				Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
1.1	Круг үйлдвэрлэлт	мян.тн	24.4	27.4	28.6	1.2	104.5%
1.2	Арматур үйлдвэрлэлт	мян.тн	11.7	6.4	6.4	-	100.0%
1.3	Төмрийн хуурай баяжмал Fe 55-58	мян.тн	1,105.1	1,523.1	1,744.5	221.4	114.5%
1.4	Төмрийн хуурай баяжмал Fe 40-54	мян.тн	355.6	510.2	448.5	(61.7)	87.9%
2	Бүтээгдэхүүн борлуулалт						
2.1	Круг борлуулалт	мян.тн	23.3	25.7	23.7	(2.0)	92.3%
2.2	Арматур борлуулалт	мян.тн	12.3	7.3	2.2	(5.1)	30.3%
2.3	Экспортын баяжмал борлуулалт	мян.тн	756.1	1,758.1	1,026.7	(731.4)	58.4%
2.4	Дотоодын баяжмал борлуулалт	мян.тн	222.9	29.2	29.2		100.0%
3	Уулын ажил						
3.1	Уулын цул	мян.м3	2,854.7	3,357.9	3,150.1	(207.7)	93.8%
3.2	Хөрс хуулалт	мян.м3	2,391.4	2,741.9	2,547.7	(194.2)	92.9%
3.3	Хүдэр олборлолт	мян.тн	1,389.9	2,463.8	2,466.3	2.5	100.1%
3.4	Хөрс хуулалтын коэффициент	харьцаа	1.72	1.11	1.03	(0.1)	92.8%

"Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

4	Хүдэр боловсруулалт						
4.1	Төмрийн хүдэр	мян.тн	1,701.9	2,436.0	2,565.8	129.8	105.3%
5	Нийт орлого	мян.төг	249,570,524.7	406,798,946.6	291,738,823.2	(115,060,123.4)	71.7%
5.1	Үйл ажиллагааны орлого	мян.төг	249,008,025.9	406,664,753.1	291,525,130.0	(115,139,623.1)	71.7%
5.1.1	Экспортын баяжмал борлуулалт	мян.төг	136,684,128.9	302,467,592.2	205,380,548.8	(97,087,043.4)	67.9%
5.1.2	Дотоодын баяжмал борлуулалт	мян.төг	7,235,912.1	1,149,380.1	1,149,380.1	-	100.0%
5.1.3	Круг борлуулалт	мян.төг	77,229,719.5	86,671,378.8	79,954,396.0	(6,716,982.8)	92.3%
5.1.4	Арматур борлуулалт	мян.төг	27,858,265.4	16,376,401.9	5,040,805.0	(11,335,596.9)	30.8%
5.2	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	562,498.8	134,193.5	213,693.2	79,499.7	159.2%
6	Нийт зардал	мян.төг	246,840,452.2	372,776,123.5	298,878,906.6	(73,897,216.8)	80.2%
6.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	114,080,894.1	183,599,478.1	124,978,015.7	(58,621,462.4)	68.1%
6.2	Борлуулалт, маркетингийн зардал	мян.төг	61,170,422.8	35,157,666.3	85,927,104.3	49,230,562.0)	63.6%
6.3	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	26,620,828.9	20,348,854.6	14,484,102.0	(5,864,752.5)	71.2%
6.4	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	-	-	-	-	-
7	Шилжих өртөг	мян.төг	44,968,306.3	33,670,124.5	73,489,684.6	39,819,560.1	218.3%
	Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	мян.төг	5,236,341.2	(114,365.4)	4,663,428.1	4,777,793.6	-4077.7%
8	Татварын өмнөх ашиг	мян.төг	52,934,720.1	67,578,582.2	71,013,029.3	3,434,447.1	105.1%
9	Цэвэр ашиг	мян.төг	40,044,001.5	51,585,000.0	51,996,560.0	411,560.0	100.8%
10	Төсөвт төлөх татвар, шимтгэл	мян.төг	64,434,440.5	85,143,276.3	72,834,205.4	12,309,070.8)	85.5%
10.1	ААНОАТ	мян.төг	12,890,718.6	15,993,582.2	19,016,469.2	3,022,887.0	118.9%
10.2	НӨАТ	мян.төг	6,492,857.5	3,991,186.0	857,070.8	(3,134,115.2)	21.5%
10.3	АМНАТ	мян.төг	25,275,694.7	40,165,685.3	27,927,955.2	(12,237,730.2)	69.5%
10.4	Бусад	мян.төг	19,775,169.7	24,992,822.7	25,032,710.2	39,887.5	100.2%
11	Ногдол ашиг	мян.төг	-	-	13,614,960.5	13,614,960.5	-
12	Ажиллагсдын тоо	хүн	1,503	1,550	1,490	(60.0)	96.1%
13	Цалингийн сан	мян.төг	54,242,942.0	69,886,637.5	70,500,809.7	614,172.2	100.9%
14	Ажиллагсдын сарын дундаж цалин	төгрөг	3,007,482	3,757,346	3,942,998	185,652.2	104.9%
15	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.84	0.87	0.84	(0.035)	96.0%
16	Борлуулсан бүтээгдэхүүний нэгж өртөг	төг/тн				-	
16.1	Баяжмалын бүрэн өртөг	төг/тн	202,197.8	192,211.1	194,239.6	2,028.5	101.1%
16.2	Цувималын бүрэн өртөг	төг/тн	2,456,448.1	2,794,423.8	2,738,177.7	(56,246.1)	98.0%
17	Хөрөнгө оруулалт	мян.төг	8,277,481.8	27,913,724.0	16,773,070.5	(11,140,653.5)	60.1%
18	Нийт авлага	мян.төг	611,155,432.0	605,781,659.4	644,930,499.7	39,148,840.4	106.5%
19	Нийт өглөг	мян.төг	849,656,010.6	845,137,402.4	967,876,312.1	122,738,909.7	114.5%
20	Ханшийн төсөөлөл	төгрөг	3,465.6	3,380.0	3,417.8	37.8	101.1%

ХТ05439@9022839

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Эдийн Засаг Хөгжлийн Яам Монгол Улсын Концессын тухай хууль болон бусад эрх зүйн актуудыг үндэслэн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах концепци төлөвлөгөө”-г шинэчлэн сайжруулах, барих, ашиглах зорилгоор концессын гэрээгээр шалгарсан компанийг ажиллуулсан боловч 8 жилийн хугацаанд концессын гэрээний гүйцэтгэл хангагдаагүй, төлөвлөсөн төсөл хөтөлбөрүүд хэрэгжээгүй, их хэмжээний өр төлбөрт оруулсан тул Засгийн газрын 2022 оны 148 дугаар тогтоолоор концессын гэрээг цуцалсан байна.

ТӨБЗГ-ын 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 123 дугаар тогтоолоор “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх, хөрөнгийг концесс эзэмшигчээс буцаан авч, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 429 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд нэгтгэжээ.

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Төрийн өмчлөлийн хувьцаа эзэмшигч нь “Эрдэнэс Монгол” ХХК байна.

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь “Дэлхийн жишигт хүрсэн уул уурхай, металлургийн цогцолборыг хөгжүүлнэ” гэж эрхэм зорилготойгоор гангийн үйлдвэрлэл болон уул уурхайн үйлдвэрлэл гэсэн үндсэн 2 чиглэлээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна.

Эх орны төмрийн хүдрээс эцсийн шатны ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангах зорилготой “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийг 2028 оны 2 дугаар хагас жилд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

“Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төсөл нь Монгол Улсын Засгийн газрын 14 мега төсөлд орсон бөгөөд Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийг Дархан-Уул аймгийн Хонгор суманд байгуулахаар баталсан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 2 удаа, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 3 удаа, 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр 1 удаа, нийт 6 удаа нэмэлт өөрчлөлт орсон;
- Төрийн болон нутгийн өмчийн тухай хууль 2024 оны 01 дүгээр сарын 12, 2024 оны 06 дугаар сарын 05, 2024 оны 12 дугаар сарын 12-нд тус тус 3 удаа нэмэлт өөрчлөлт;
- 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр “Үндэсний баялгийн сангийн тухай” хууль шинээр батлагдсан;
- Монголын хөрөнгийн биржийн 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан ТУЗ-ийн “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам”-д 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон;
- “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн захиргаа, ҮЭХ-той байгуулсан 2023-2025 оны Хамтын гэрээнд Монголын “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээр”-т нийцүүлж нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дотоод аудитын чиг үүргийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ын дэргэдэх Дотоод аудитын алба хэрэгжүүлсэн байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн тохироогүй буюу 2015 онд боловсруулан баталснаас хойш холбогдох стандарт, хууль, журам зааварт нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 210,516,604.0 сая төгрөгөөр буюу 19.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,957,616.3	52,122,935.3	39,165,319.0
Авлага	556,389,118.6	629,210,596.6	72,821,478.0
Урьдчилгаа	54,766,313.3	15,719,903.1	(39,046,410.2)
Бараа материал	309,643,943.8	386,527,856.0	76,883,912.2
Үндсэн хөрөнгө	121,806,750.8	182,499,055.8	60,692,305.0
Нийт хөрөнгө	1,055,563,742.8	1,266,080,346.8	210,516,604.0
Өр төлбөр	849,656,010.6	967,876,312.1	118,220,301.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	205,907,732.2	298,204,034.6	92,296,302.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,055,563,742.8	1,266,080,346.8	210,516,604.0

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 52,122.9 сая төгрөг болж 39,165.3 сая төгрөгөөр өссөн нь 2023 оны 9 дүгээр сараас эхлэн биржийн арилжаагаар төмрийн хүдрээ борлуулж эхэлснээс хойш хэрэгжсэн гэрээний дэнчингийн төлбөрүүд орж эхэлсэн, биржийн арилжаа

нэмэгдэж хэд хэдэн арилжааны төлбөр 95 хувьтай орж ирснээс шалтгаалсан. 2024 оны 4 дүгээр улиралд биржийн 18 арилжааны төлбөрт 72,917.3 сая төгрөг орж ирсэн байна.

Авлагын үлдэгдэл 629,210.6 сая төгрөг болж 72,821.5 сая төгрөгөөр өссөн нь худалдан авагчаас биржийн 89 гэрээний дагуу Монголын хөрөнгийн биржид байршуулсан 27,719.4 сая төгрөгийн дэнчингийн мөнгийг авлагаар бүртгэсэн, урьдчилж төлсөн 45,596.0 сая төгрөгийн тооцоог авлагаар ангилж бүртгэсэнтэй холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдлийн 39,046.4 сая төгрөгийн бууралт нь дээрх дансны үлдэгдлийг авлага руу ангилж бүртгэсэн тооцооноос шалтгаалсан байна.

Бараа материалын үлдэгдэл 76,883.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бэлэн бүтээгдэхүүний өсөлтөөс голлон шалтгаалсан байна. Тодруулбал тайлант онд олборлолт болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа сайжирч төлөвлөгөө биелсэн боловч вагон тээврийн тендер шалгаруулалт хэд хэдэн удаа амжилтгүй болсны улмаас борлуулалт багасаж, уурхайн бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 72,162.7 сая төгрөгөөр нэмэгджээ.

Үндсэн хөрөнгө 182,499.1 сая төгрөг болж 60,692.3 сая төгрөгөөр өссөн гол шалтгаан нь тайлант хугацаанд эзэмших эрхтэй 22 газрыг бүртгэлд тусгасан, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж 56,497.3 сая төгрөгийн дахин үнэлгээ нэмэгдлийг хүлээн зөвшөөрсөн, 5,461.7 сая төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авсан, 11,353.8 сая төгрөгийн их засварыг капиталжуулсантай холбоотой байна.

Мөн ТӨБЗГ-ын 2024 оны 397 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэх захирлын 2024 оны А/315 тушаалаар элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1,046 нэрийн 2,070.6 сая төгрөгийн хөрөнгийг актлахаас 1,040 нэрийн 2,050.1 сая төгрөгийн хөрөнгийг устгаж данс бүртгэлээс хассан нь дотоод хяналт хангалтгүйгээс данснаас хасах жагсаалтад давхар оруулсан 6 нэрийн 20.5 сая анхны өртөгтэй төгрөгийн дахин үнэлэгдсэн хөрөнгөнөөс шалтгаалжээ.

Өр төлбөр 967,876.3 сая төгрөг болж 118,220.3 сая төгрөгөөр өссөн нь биржийн гэрээний төлбөрөөс урьдчилж орсон орлого 97,792.4 сая төгрөгөөр, тайлант оны татварын өглөг 21,924.8 сая төгрөгөөр өссөн зэргээс шалтгаалсан байна.

Эзний өмч 298,204.0 сая төгрөг болж 92,296.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн цэвэр ашиг 51,996.6 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 56,497.3 сая төгрөгөөр өссөн, мөн 2023 оны ногдол ашигт зарласан 13,615.0 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн залруулгын 2,582.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 01/04 дугаартай тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 387,254.5 сая төгрөг, нийт зардлыг 341,384.2 сая төгрөг буюу 34,671.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 45,114.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Харин Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 77 дугаартай тогтоолоор нийт орлогыг 406,798.9 сая төгрөг, нийт зардлыг 339,106.0 сая төгрөг буюу 51,585.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тодотгож, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 27,913.7 сая төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 291,738.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 225,389.2 сая төгрөгийн зардал гаргаж, 71,013.0 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай, 51,996.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 291,738.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 115,060.1 сая төгрөг буюу 28.2 хувиар тасарсан нь барилгын зах зээл дээрх арматурын үнийн бууралт, арматурын борлуулалтын төлөвлөгөө 5.1 мянган тонноор буюу 11,335.6 сая төгрөгөөр тасарсан болон төмрийн хүдрийн баяжмалын уурхайгаас терминал хүртэлх богино зайн тээврийн тендерийн үйл ажиллагаанд оролцогч байхгүй, гомдол гарснаар тайлант оны 8 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд авто тээвэр саатаж борлуулалт хийгээгүй, мөн ачааны хагас вагоны тендерийг зарласан боловч зах зээл дээрх түрээсийн үнэ нэмэгдсэнээр оролцогч байхгүй зэргээс шалтгаалан төмрийн хүдрийн баяжмал борлуулалтын төлөвлөгөө 731.4 мянган тонноор буюу 97,087.0 сая төгрөгөөр тасарсан зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 225,389.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 113,716.8 сая төгрөг буюу 33.5 хувиар доогуур байгаа нь борлуулалтын төлөвлөгөө биелээгүйгээс вагон тээвэр, вагон түрээсийн зардал буурсан, АМНАТ-ыг зах зээлийн үнээр биш биржийн гэрээний үнээр тооцсоноор татварын зардал буурсан зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 166 нэр төрлийн 27,913.7 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс 19,494.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2024 онд санхүүжүүлэхээр төлөвлөн 135 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 16,773.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн нь 60 хувийн биелэлттэй байна.

Тайлант онд цэвэр ашиг 51,996.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 411.5 сая төгрөгөөр илүү байгаа нь биржийн арилжаа хийгдэж дуудлага худалдаагаар төлөвлөснөөс өндөр үнээр борлуулалт хийсэн, үйлдвэрлэлийн түүхий эд материалын зардлыг хэмнэсэн зэрэг нь нөлөөлжээ.

Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК нь 2024 онд Монгол Улсын Хуримтлалын санд 13,614.9 сая төгрөгийг, ТӨБЗГ-т түрээсийн орлогын 40 хувь буюу 170.9 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Пийк ОМ Аудит” ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Чанцалдиймаа, захирал Б.Жаргалсайхан нар анхан шатны хяналтыг, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар хоёр дахь шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК 2024 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02/393 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 1,055,563.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 10,555.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитаар Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд нийт 38 асуудалд горим сорил хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус байгууллага хэмнэлтийн талаар төлөвлөгөө гарган ажилласан бөгөөд өртөг зардал бууруулах инновациар 200 тонны бэлдэц хайчлах хайчны SD200 ир 20 ширхгийг дотооддоо шинээр хийж, гадаадаас авах зардлыг нийт 70.0 сая төгрөгөөр бууруулсан. Мөн импортоор худалдан авдаг металл шингэлэх зуухны шаар тосох 3 ширхэг шанага, шингэн металл зөөвөрлөх шанагыг шинээр хийж цаг хугацаа болоод зардлын хэмнэлт гаргасан байна. Түүнчлэн Гангийн үйлдвэрийн хайлах хэсэгт хэрэглэдэг импортоор оруулж ирдэг феррохром, ферромарганцын оронд хромжуулсан төмөр, башмак ашиглаж зардлыг бууруулсан, доторлогооны материал болон бусад материалыг 2,812.9 сая төгрөгөөр хэмнэсэн, Гангийн үйлдвэрлэлийн завсрын шанага халаах үйл ажиллагаанд өөрчлөлт оруулж, уул уурхайн автосамосвалын даац ашиглалтыг нэмэгдүүлснээр нийтдээ 3,832.4 сая төгрөгөөр зардлыг бууруулж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 7,452.3 сая төгрөгийн зөрчлөөс 7,381.9 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 70.4 сая төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 28 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 156 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байгаа нь өмнөх оны аудитаар өгсөн “Шилэн дансны цахим системд мэдээллийг үнэн зөв, иж бүрэн зохих хугацаанд нь байршуулах” зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шаардлагатай мэдээллүүдийг эрх бүхий дээд байгууллагаар батлуулан шийдвэрлүүлж, шилэн дансны цахим системд байршуулах мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, цаг хугацаанд нь мэдээлж байх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК нь Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, “Ахмадын сан” байгуулж ажиллаагүй байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадын санг байгуулж ажиллах, Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

2. ТӨБЗГ-ын 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 123 дугаар тогтоолоор “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх, хөрөнгийг концесс эзэмшигчээс буцаан авч, Засгийн газрын 2022 оны 11 сарын 30-ны өдрийн 429 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд нэгтгэснээс одоог хүртэл гүйцэтгэх

захирлын үүрэг гүйцэтгэгчдийг түр томилсоор байна. Тус компанийн сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлсний дагуу гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулж, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг байгуулан, санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан тохиолдолд үндсэн гэрээний хугацаагаар сунгах зохицуулалтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5-д “Хөдөлмөрийн гэрээний хугацааг хуанлийн жил, сар, өдрөөр, эсхүл энэ хуулийн 50.1.3, 50.1.4, 50.1.5, 50.1.6-д заасан ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хугацаа, зайлшгүй бий болох үйл явдлаар тодорхойлно”, “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн дүрмийн 3 дугаар бүлгийн 3.3.2-т “Гүйцэтгэх захирал нь доорх шалгуурыг хангасан байх бөгөөд гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулж сонгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулж, шалгарсан гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг байгуулж, санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан тохиолдолд үндсэн гэрээний хугацаагаар сунгах зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллах, Хөдөлмөрийн тухай хууль болон “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-д зөвлөмж хүргүүллээ.

3. “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн өндөрлөсөн жилийн хувьд гэрээ нэртэй архивын нэгж боть баримтууд байгаа боловч тэдгээрийг тухайн жилийн батлагдсан гэрээг бүрэн хавсаргасан эсэхийг нотлох, тулгах гэрээний нэгдсэн жагсаалт байхгүй байна. Тус байгууллагын худалдан авалтын гэрээ худалдан авах ажиллагааны албанд сонгон шалгаруулалтын дугаараар, борлуулалтын гэрээнүүд борлуулалтын албанд, бусад гэрээ захиргаа удирдлагын газар гэх мэтээр тус тусдаа хариуцан хөтөлдөг, гэрээнүүд нэгдсэн бүртгэлгүй, нэгдсэн дугааргүй, гэрээнүүдийн төрлөөс хамаарч ямар ажилтан бэлтгэж, ямар албан тушаалтан, албаар хянуулан батлуулж, аль алба хэсэгт, ямар ажилтанд хадгалж, ямар зөвшөөрлөөр гэрээний төлбөрийг шилжүүлэх, гэрээнд заагдсан бараа ажил үйлчилгээг хүлээн авах зэрэг гэрээний хөдөлгөөнийг харуулсан батлагдсан бүдүүвчийг мөрдөхгүй, гэрээний нэгдсэн удирдлага байхгүйгээс гэрээний нэгдсэн бүртгэлгүй, бүрэн биш, эмх цэгцгүй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-д “Байгууллагын ажилтан албан хэрэг хөтлөлтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 35.4.3-д “Баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах”, 35.4.7-д “Баримт бичгийг байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй шилжүүлэх”, 42.5-д “Бичиг хэрэгт бүртгэгдээгүй баримт бичгийг удирдлагад танилцуулах, хянан шийдвэрлэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээг холбогдох хуулийн дагуу бүртгэж, архивлаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

4. Тайлант онд худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө холбогдох хуулийг зөрчин 70.4 сая төгрөгийн бараа үйлчилгээний худалдааны нэр, марк, загварыг заасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч,

нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө бараа үйлчилгээний нэр, марк, загвар заахгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

5. “Төмрийн хүдрийн хуурай баяжмал борлуулах экспортын гэрээ”-ний сунгалт хийгдээгүйн улмаас гэрээний дагуу 22 харилцагчаас урьдчилж орсон 32,645.0 сая төгрөгийн хүдрийн баяжмалыг нийлүүлэх боломжгүй, борлуулалт хэрэгжээгүй байгаагаас дотоодын 2, гадаадын 7, нийт 9 харилцагчийн 2021, 2023, 2024 онуудад үүссэн 26,674.8 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.3-т “Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Төмрийн хүдрийн хуурай баяжмал борлуулах экспортын гэрээ”-ний сунгалтыг хийж, борлуулалтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

6. Тус байгууллагын “Өгөөж гурил” ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 21-нд байгуулсан ДТҮ/АГ/202203 дугаартай, 3,976.0 сая төгрөгийн үнийн дүнтэй “Хүдэр тээвэрлэлтийн гэрээ”-нд 2023 оны 2 удаагийн нэмэлт гэрээнүүдээр гэрээний хугацааг сунгаж, хүдэр, хүдрийн баяжмалын тонн тутмыг тээвэрлэх зардлыг нэмсэн байна. Талуудын 2024 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн гэрээ дүгнэсэн актаар 6,053.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь үндсэн гэрээний дүнгээс 2,077.3 сая төгрөгөөр илүү буюу холбогдох хуульд заасан анхны өртгийн 15 хувиас ихээхэн хэмжээгээр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлаагүй бол уг нэмэлт, өөрчлөлт илт хууль бус байна”, 40 дүгээр зүйлийн 40.1-д “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно”, 40.1.1 “Захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах”, 34 дүгээр зүйлийн 34.1-д “Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно”, 34.1.4-д “Нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд нийцсэн, хүчин төгөлдөр гэрээгүйгээр хүдэр тээвэрлэлтийн төлбөрийг шилжүүлсэн зөрчлийг арилгаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

7. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2023, 2024 онуудын “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй, тус байгууллагын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтнүүдийн хариуцаж бэлтгээгүй, 2023 оны жилийн

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон бол төлбөрийн акт тогтоох үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Шийдвэргүйгээр олгосон 2,170,000.00 (Хоёр сая нэг зуун далан мянган) төгрөгийн урамшуулалт цалинг Я.Өлзийболдоор төлүүлж, Төрийн сан дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх

4525050278

захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 03 сар 14 өдөр

Дугаар 01/99-24010611-ХТТ-2025/25/10-177 Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компанийн албан томилолтын зардлын 2024 оны эхний 5 сарын анхан шатны баримтыг түүвэрлэн шалгахад удирдамжид заасан хугацаанд хамаарахгүй 2,804,271.00 төгрөгийн 47 ширхэг шатахууны цахим төлбөрийн баримтыг хавсаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.МӨНХЦЭЦЭГ

4525040270



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 03 сар 14 өдөр

Дугаар 02/80-24010611-2025-2025/03/14-03-03 Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК нь ДТҮ/2024/ХАГ/10 дугаартай "Хөлсөөр ажиллах гэрээ"-ний заалтыг хэрэгжүүлээгүй, гэрээний хэрэгжилт, үр дүнг сар бүр тайлагнаагүй ажилтанд 22,841,000.00 төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн ДТҮ/2024/ХАГ/10 дугаартай "Хөлсөөр ажиллах гэрээ"-ний 2.4-д "Б" тал нь гэрээний хугацаанд хийж гүйцэтгэх ажлыг "А" талын удирдамж, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх бөгөөд хэрэгжилт, үр дүнг бичгээр сар бүр "А" тал болон түүний эрх олгосон этгээдэд тайлагнана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Ажлын хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй ажилтанд цалин олгож байгаа зөрчлийг таслан зогсоож, арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ийн
АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.МӨНХЦЭЦЭГ



4525040273



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 09/87-24010611-2AA-2225P5/HA-ET Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн агуулахын удирдлага, зохион байгуулалт, хяналтын систем хангалтгүй, агуулахын бүртгэлийн тусгайлсан программ байхгүй, бараа материалын нэр кодыг замбараагүй янз бүрээр бүртгэдэг зэргээс шалтгаалан төрийн өмч дутагдах, чанар байдлаа алдаж муудах, ашиглах боломжгүй болох, оновчгүй худалдан авалт төлөвлөх, компанийн ашигт ажиллагаа багасах, сэлбэг хэрэгслийг "хайж олох"-д маш их хугацаа зарцуулах эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.3-т "Тооллогын комисс нь агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах үүрэгтэй", Гүйцэтгэх захирлын 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/121 дугаар тушаалаар баталсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн журам"-ын 4.1-д "Зөвлөл нь Компанийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана", Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн хувьцаа эзэмшигчтэй гүйцэтгэх захирлын байгуулсан 2024 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн ЭМГЛ/ГЗ-16/20240708 дугаартай Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээний 4.19-д "Гүйцэтгэх захирал нь компанийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодыг хяналтыг зохион байгуулж, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын асуудлыг хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ-НЬ:**

1. Бараа материалын агуулахын удирдлага, зохион байгуулалт, хяналтын систем хангалтгүй, өдөр тутам агуулахын бүртгэл хөтлөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

009040028

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 10/ББ-24010611-ХА-2025/10-СТ-ТХ Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компанийн нярвууд "Агуулахын бүртгэл" хөтлөөгүй, ажлын байрны тодорхойлолтод "анхан шатны баримтыг хөтлөх, тэдгээрт үндэслэн бараа материалыг орлогодож, зарцуулах, хөдөлгөөнийг санхүүгийн программ бүртгэлд оруулах" зэргээр тусгасан боловч "Агуулахын бүртгэл хөтлөх" гэж тусгайлан оруулаагүй, "Өөрийн ажил үүрэгтэй холбоотой хууль, дүрэм, журам компанийн дотоод журам болон бусад журмуудыг хэрэгжүүлж мөрдөж ажиллах" гэж ерөнхий заалтаар зохицуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын хавсралтын 3.5-д "Агуулахын бүртгэл, НХМаягт БМ-5, "Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрд мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор агуулахын бүртгэлийг эд хариуцагч материалын нэр төрөл, зэрэг, дугаар бүр дээр нээж хөтөлнө. Агуулахын бүртгэлийг дэвтэр маягтаар хөтөлнө. Түүний хуудас нэг бүрийг дугаарлан, хуудасны тоог тавьж хариуцагч нягтлан бодогч нь эд хариуцагчид жилийн эхэнд хүлээлгэн өгнө. Материал, үнэ бүхий зүйлийн хөдөлгөөнийг эд хариуцагчид "Бараа, материалын үнэ бүхий зүйлийн орлого, зарлагын баримт"-ийг үндэслэн агуулахын бүртгэлийг биет нэгжээр хөтөлж өдөр тутмын үлдэгдлийг тодорхойлохын хамт тайлант хугацаанд хариуцагч нягтлан бодогчоор тайлангаа хянуулж үлдэгдлийг батлуулан гарын үсэг зуруулна. Агуулахын бүртгэлийн хуудас бүрийг дугаарлаж, эцсийн хуудсанд нягтлан бодогч нийт дугаарын тоог тавьж, санхүүгийн тэмдэг дарна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Агуулахын бүртгэл хөтлөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

009040031

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 11/89-24010611-2024-2025/03/14-01-01 Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь нярав, эд хариуцагчдыг ажилд шинээр орох, ажлаас гарах, ээлж солилцох зэрэг зайлшгүй шаардлагатай тасалбар хугацаануудад бараа материалын тооллого явуулдаггүй, зөвхөн ажлын байрыг хүлээлгэн өгдөг ба бараа материал үнэ бүхий зүйлийг хариуцаж буй ажилтнуудтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-т “Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.2-т “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй нь албан шаардлага өгөх үндэслэл болно” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Эд хариуцагчид ээлж солих болон шинэ эд хариуцагчийг ажилд томилох тухай бүрд тооллого хийхгүй байгаа таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ

009040036



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 12/90-24010611-2024-2025/14-СД-ТӨА Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төмөртолгойн хүдрийн уурхайн бараа материалаас "Ачигчийн сэлбэг-ийг түүвэрлэн хяналтын тооллого явуулахад 103 нэр төрлийн 596 ширхэг 218,901,244.6 төгрөгийн бараа материал илүү, 88 нэр төрлийн 648 ширхэг 124,786,438.2 төгрөгийн бараа материал дутуу, мөн бүртгэлд тусгагдаагүй, нэг бүрийн үнэ тодорхойгүй 105 нэр төрлийн 726 ширхэг сэлбэг материалыг тоолсон ба хэвийн, үнэ цэнээ алдаагүй бараа материалын ангилалд бүртгэлтэй байгаа тус уурхайд ашиглахаа больсон 52 нэр төрлийн 555 ширхэг сэлбэг хэрэгсэл тоологдлоо. Харин тус байгууллагын өмнөх тооллогын комиссууд хөрөнгийг нэг бүрчлэн тоолоогүй, чанар байдлыг тодорхойлоогүй, тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.3-т “Тооллогын комисс нь агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.2-т “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй нь албан шаардлага өгөх үндэслэл болно” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Бараа материалыг нэг бүрчлэн тоолоогүй, чанар байдлыг тодорхойлоогүй, тооллогыг үр дүнтэй зохион байгуулахгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

009049037

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ийн
АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 13/01-24010611-800-2025/25/11-07 Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гангын үйлдвэрийн 2024 оны эхний 7 сарын сэлбэг материалын дансны анхан шатны баримтуудыг түүвэрлэн шалгахад батлагдсан захиалгын хуудсанд зааснаас илүү тоо ширхгээр худалдан авсан болон захиалгын хуудас огт байхгүй, дууссан эсвэл өөр захиалгын хуудас хувиран хавсаргасан зэрэг 168,488,300.00 төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.3-т "Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Захиалгын хуудсаар баталгаажгаагүй байхад бараа материалын худалдан авалт хийж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

009040093

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 15/93-240106/11-ДТН-2025/25/24-ДТН-ТД Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэлгүйгээр, бичиг хэргийн зардлыг 13,196,714.00 төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх арга хэмжээг авч ажиллана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.5-д "Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн бол албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.МӨНХЦЭЦЭГ



003040176



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 16/94-24010611-2024-2025/25/11-СТ-Д Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК нь 2024 оны 133,790,558.05 төгрөгийн урьдчилж төлсөн тооцоо, концесс хэрэгжүүлэгчийн үед үүссэн 927,621,267.15 төгрөгийн баяжмалын авлага, мөн 2023 оны 13,770,436,817.65 төгрөгийн баяжмалын урьдчилж орсон орлого, 739,096,974.40 төгрөгийн баяжмалын авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 20.2.6-д "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.2.7-д "Авлагын баталгаажилт" хэсэгт "Тайлант хугацаа бүрийн эцэст байгаа бүх төрлийн авлагын үлдэгдлийг тооцоолж, түүнийг төлөхөө хүлээн зөвшөөрсөн бичгэн баталгаа (тооцоо нийлсэн акт)-г зохих байгууллага, иргэдээс гаргуулан авна", 4.6.6-д "Өр төлбөрийн баталгаажуулалт"-д "Тайлант хугацаа бүрийн эцэст байгаа бүх төрлийн өглөгийн үлдэгдлийг тооцоолж, түүнийг төлөхөө хүлээн зөвшөөрсөн бичгэн баталгаа (тооцоо нийлсэн акт)-г зохих байгууллага, иргэдээс гаргуулан авна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.7-д "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Баяжмалын авлага, баяжмалын урьдчилж орсон орлогыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

009040186

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 03 сар 14 өдөр

Дугаар 07/85-24010611-2111-2025/2111-0111-0111 Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн өндөрлөсөн жилийн хувьд гэрээ нэртэй архивын нэгж боть баримтууд байгаа боловч тэдгээрийг тухайн жилийн батлагдсан гэрээг бүрэн хавсаргасан эсэхийг нотлох, тулгах гэрээний нэгдсэн жагсаалт байхгүй байна. Тус байгууллагын худалдан авалтын гэрээ худалдан авах ажиллагааны албанд сонгон шалгаруулалтын дугаараар, борлуулалтын гэрээнүүд борлуулалтын албанд, бусад гэрээ захиргаа удирдлагын газар гэх мэтээр тус тусдаа хариуцан хөтөлдөг, гэрээнүүд нэгдсэн бүртгэлгүй, нэгдсэн дугааргүй, гэрээнүүдийн төрлөөс хамаарч ямар ажилтан бэлтгэж, ямар албан тушаалтан, албаар хянуулан батлуулж, аль алба хэсэгт, ямар ажилтанд хадгалж, ямар зөвшөөрлөөр гэрээний төлбөрийг шилжүүлэх, гэрээнд заагдсан бараа ажил үйлчилгээг хүлээн авах зэрэг гэрээний хөдөлгөөнийг харуулсан батлагдсан бүдүүвчийг мөрдөхгүй, гэрээний нэгдсэн удирдлага байхгүйгээс гэрээний нэгдсэн бүртгэлгүй, бүрэн биш, эмх цэгцгүй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-д "Байгууллагын ажилтан албан хэрэг хөтлөлтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 35.4.3-д "Баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах", 35.4.7-д "Баримт бичгийг байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй шилжүүлэх", 42.5-д "Бичиг хэрэгт бүртгэгдээгүй баримт бичгийг удирдлагад танилцуулах, хянан шийдвэрлэхийг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Гэрээг холбогдох хуулийн дагуу бүртгэж, архивлаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

4525040285

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 02 сар 14 өдөр

Дугаар 04/22-24010611-ХАА-2025/23/НО-СА-ТА Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын "Өгөөж гурил" ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 21-нд байгуулсан ДТҮ/АГ/202203 дугаартай, 3,976,000,000.00 төгрөгийн үнийн дүнтэй "Хүдэр тээвэрлэлтийн гэрээ"-нд 2023 оны 2 удаагийн нэмэлт гэрээнүүдээр гэрээний хугацааг сунгаж, хүдэр, хүдрийн баяжмалын тонн тутмыг тээвэрлэх зардлыг нэмсэн байна. Талуудын 2024 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн гэрээ дүгнэсэн актаар 6,053,318,145.00 төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь үндсэн гэрээний дүнгээс **2,077,318,145.00** төгрөгөөр илүү буюу холбогдох хуульд заасан анхны өртгийн 15 хувиас ихээхэн хэмжээгээр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлаагүй бол уг нэмэлт, өөрчлөлт илт хууль бус байна", 40 дүгээр зүйлийн 40.1-д "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно", 40.1.1 "Захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах", 34 дүгээр зүйлийн 34.1-д "Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно", 34.1.4-д "Нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол албан шаардлага өгөх үндэслэл болно" 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Хуульд нийцсэн, хүчин төгөлдөр гэрээгүйгээр хүдэр тээвэрлэлтийн төлбөрийг шилжүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

4525040276

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 03 сар 14 өдөр

Дугаар 057/3-24010611-2024-2025/3/14-01-01 Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2023, 2024 онуудын "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-д тусгагдаагүй, тус байгууллагын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтүүдийн хариуцаж бэлтгээгүй, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй "Дараа төлбөрт худалдах, худалдан авах гэрээ"-г 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдөр баталгаажуулж, "Барловорлд Монголиа" ХХК-аас "Тоног төхөөрөмж, сэлбэг, засвар, үйлчилгээ, тосны шинжилгээ, бараа" зэргийг шууд худалдан авахаар гэрээлсэн байна. Энэхүү гэрээнд эрх зүйн үндэслэл, хэрэглэх хуулийг тусгаж оруулаагүй, "3. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл хэсгийн 3.2 Худалдан авагч талын худалдан авах барааны үнэ нь тухайн үед нийлүүлэгч талаас гаргаж өгсөн үнийн саналд үндэслэнэ" гэсэн тул барааны үнэ тодорхойгүй, "3.1. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл хэсэгт худалдан авагч тал нь 500 сая төгрөгийн үнийн дүн бүхий барааг нийлүүлэгч талаас дараа төлбөрт нөхцөлөөр худалдан авах эрхтэй" гэснээс өөрөөр гэрээний нийт үнийн дүнг тусгаагүйгээс 2023 оны 10 дугаар сарын 11-ээс 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 13 удаагийн шилжүүлгээр нийт 3,596,944,376.85 төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-д "Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Иргэний хуулийн 262 дугаар зүйлийн 263.2-т "Гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана", 263.2.1-д "Бэлэн мөнгөөр төлөх төлбөрийн хэмжээ", 263.2.2-т "Хэсэгчлэн хийх төлбөрийн хэмжээ, хугацаа" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол албан шаардлага өгөх үндэслэл болно", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, шууд худалдан авалтын гэрээгээр тоног төхөөрөмж, сэлбэг материал бэлтгэх зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг

4523040279

2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 03 сар 14 өдөр

Дугаар 06/84-24010611-2025-2025/14-СА-ТА Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани Барловорлд Монголиа ХХК-тай 2024 оны 5 сарын 31-ны өдөр 1,340,724,894.00 төгрөгийн "Ажил гүйцэтгэх захиалгын гэрээ"-г шууд байгуулж, урьдчилгаа төлбөр шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-д "Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол албан шаардлага өгөх үндэслэл болно", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Хууль зөрчин, шууд худалдан авалтын гэрээ байгуулж, урьдчилгаа шилжүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ



4525040282



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 03 сар 24 өдөр

Дугаар 08/86-24010611-ДТТ-2025/11А-07А-ТД Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө 7 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээний 366,953,537.00 төгрөгийн өртгийг 28 хэсэгт хувааж, шууд худалдан авалт зохион байгуулахаар төлөвлөсөн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 46 дугаар зүйлийн 46.1.4-т "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтын Хоёрдугаар бүлгийн 4-ийн 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол албан шаардлага өгөх үндэслэл болно", 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх үндэслэл болно" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулахдаа нийт төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

4525040288

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Чагнаадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Мөнхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ийн
АХЛАХ АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ

